

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/53/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

| | |
|---|----|
| Товчилсон үгийн жагсаалт..... | 3 |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..... | 5 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 5 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... | 6 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 10 |
| 3. Аудитын тайлан..... | 11 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 12 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 16 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 16 |
| 3.8 Аудитын гол асуудал | 17 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 17 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 18 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 18 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 18 |
| 4.1 Залруулсан алдаа | 18 |
| 4.2 Төлбөрийн акт..... | 19 |
| 4.3 Албан шаардлага | 20 |
| 4.4 Зөвлөмж..... | 21 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 21 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| НХМ | Нэг хэвийн маягт |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ОБГ | Онцгой байдлын газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 011/45
танай _____-ны № _____-Т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Н.БАТБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ



D 2022/2022.02.25/АДБААН/19020405

Л

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэ | Эцсийн үлдэгдэ |
|------------|--|-------------------------|-------------------------|
| | | | /Төгрөгөөр/ |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 91,497,443.81 | 86,151,043.81 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 91,497,443.81 | 86,151,043.81 |
| 354 | Хангамжийн материал | 66,774,143.81 | 71,001,043.81 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,782,060.00 | 2,170,260.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 21,800,318.50 | 26,248,518.50 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 43,191,765.31 | 42,582,265.31 |
| 35600 | Мал амьтад | 24,723,300.00 | 15,150,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,507,613,378.69 | 1,447,609,622.49 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,507,613,378.69 | 1,447,609,622.49 |
| 392 | Биет хөрөнгө | 1,420,428,212.08 | 1,360,479,455.90 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,416,120,218.62 | 1,416,120,218.62 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -251,361,625.51 | -322,568,583.08 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 135,288,686.00 | 133,018,020.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -73,021,324.95 | -78,436,075.63 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 83,008,923.12 | 68,669,899.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -43,487,226.69 | -28,899,123.39 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,485,446.17 | 42,009,066.17 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,556,375.48 | -37,727,473.40 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 284,317,798.00 | 313,199,116.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -136,366,307.20 | -144,905,608.39 |
| 393 | Биет бус хөрөнгө | 87,185,166.61 | 87,130,166.59 |
| 39301 | Програм хангамж | 2,907,485.00 | 1,740,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,838,318.39 | -725,833.41 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 86,116,000.00 | 86,116,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,599,110,822.50 | 1,533,760,666.30 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 98,773.97 | 98,773.97 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 98,773.97 | 98,773.97 |
| 413 | Өглөг | 98,773.97 | 98,773.97 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 98,773.97 | 98,773.97 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,599,012,048.53 | 1,533,661,892.33 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,599,012,048.53 | 1,533,661,892.33 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 851,574,968.37 | 851,574,968.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 851,574,968.37 | 851,574,968.37 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 335,544,831.86 | 271,081,293.24 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 335,544,831.86 | 336,431,449.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -65,350,156.20 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 411,892,248.30 | 411,005,630.72 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,599,110,822.50 | 1,533,760,666.30 |

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | /Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|--------------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 411,274,716.90 | 405,334,701.90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 79,719,525.00 | 25,308,318.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 79,719,525.00 | 25,308,318.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 79,719,525.00 | 25,308,318.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 79,719,525.00 | 25,308,318.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО | 331,555,191.90 | 380,026,383.90 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 32,870,591.90 | 36,726,883.90 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 2,208,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,836,991.90 | 31,552,738.90 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,033,600.00 | 2,966,145.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 298,684,600.00 | 343,299,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 298,684,600.00 | 343,299,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 369,856,476.80 | 470,684,858.10 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 338,951,608.20 | 470,684,858.10 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 325,408,424.20 | 423,508,435.99 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 168,437,314.30 | 186,245,024.49 |
| 210101 | Үндсэн цалин | 124,616,860.20 | 136,937,269.85 |
| 210102 | Нэмэгдэл | 25,062,643.23 | 25,712,837.50 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,757,810.87 | 23,594,917.14 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,056,961.97 | 24,164,857.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,056,961.97 | 16,734,039.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,857,762.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,486,210.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 371,318.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,715,526.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,795,548.00 | 28,976,524.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,245,774.00 | 4,727,550.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,549,774.00 | 24,248,974.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,015,008.00 | 36,145,883.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,558,300.00 | 2,022,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,771,308.00 | 22,713,003.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,417,800.00 | 1,309,030.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 196,400.00 | 366,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 71,200.00 | 161,450.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 9,573,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 101,600.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 101,600.00 | 00.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 00.00 | 6,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 6,400,000.00 |
| 2107 | Томилголт, зочны зардал | 2,003,000.00 | 1,929,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,003,000.00 | 1,929,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,956,180.00 | 1,725,461.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,246,655.00 | 330,366.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 236,025.00 | 280,125.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 319,500.00 | 356,170.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 154,000.00 | 154,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,042,811.93 | 137,921,186.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 29,460,901.00 | 47,136,112.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 45,581,910.93 | 90,785,074.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,448,052.60 | 47,176,422.11 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,543,184.00 | 965,633.33 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 916,700.00 | 965,633.33 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 30,904,868.60 | 46,210,788.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,904,868.60 | 46,210,788.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 41,418,240.10 | -65,350,156.20 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 41,418,240.10 | -65,350,156.20 |

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | | | /Төгрөгөөр/ |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 333,255,191.90 | 380,026,383.90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,700,000.00 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,700,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,700,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 331,555,191.90 | 380,026,383.90 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 32,870,591.90 | 36,726,883.90 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 00.00 | 2,208,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 30,836,991.90 | 31,552,738.90 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,033,600.00 | 2,966,145.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 298,684,600.00 | 343,299,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 298,684,600.00 | 343,299,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 325,557,191.90 | 372,526,383.90 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 325,557,191.90 | 372,526,383.90 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 293,735,623.30 | 325,355,595.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 181,575,494.87 | 185,897,031.49 |
| 210101 | Үндсэн цалин | 136,011,336.78 | 133,747,487.29 |
| 210102 | Нэмэгдэл | 24,842,716.15 | 26,120,807.13 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,721,441.94 | 26,028,737.07 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 20,446,492.43 | 24,107,387.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,791,352.93 | 16,676,569.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 414,471.40 | 1,857,762.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 331,577.17 | 1,486,210.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 80,148.10 | 371,318.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 828,942.83 | 3,715,526.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,795,548.00 | 28,565,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,245,774.00 | 4,716,926.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,549,774.00 | 23,848,974.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,278,000.00 | 20,798,755.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,244,900.00 | 2,266,466.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,431,400.00 | 15,340,940.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,270,300.00 | 1,311,254.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 331,400.00 | 680,095.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 1,200,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 183,300.00 | 199,083.33 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 183,300.00 | 199,083.33 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 800,000.00 | 6,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 6,400,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,003,000.00 | 1,929,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,003,000.00 | 1,929,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,935,887.00 | 2,236,834.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийглэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,226,362.00 | 869,634.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 287,525.00 | 288,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 301,000.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 154,000.00 |

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|----------------------|----------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,717,901.00 | 55,221,104.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,717,901.00 | 55,117,104.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 104,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31,821,568.60 | 47,170,788.78 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 916,700.00 | 960,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 916,700.00 | 960,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 30,904,868.60 | 46,210,788.78 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 30,904,868.60 | 46,210,788.78 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 7,698,000.00 | 7,500,000.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 00.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 7,698,000.00 | 7,500,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,698,000.00 | 7,500,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,698,000.00 | 7,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,698,000.00 | 7,500,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -7,698,000.00 | -7,500,000.00 |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | / төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|---|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 851,574,968.37 | 411,892,248.30 | 294,126,591.76 | 00.00 | 1,557,593,808.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 851,574,968.37 | 411,892,248.30 | 294,126,591.76 | 00.00 | 1,557,593,808.43 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайланг үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 41,418,240.10 | 00.00 | 41,418,240.10 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 851,574,968.37 | 411,892,248.30 | 335,544,831.86 | 00.00 | 1,599,012,048.53 |
| D01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 851,574,968.37 | 411,892,248.30 | 335,544,831.86 | 00.00 | 1,599,012,048.53 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 886,617.58 | 00.00 | 886,617.58 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 851,574,968.37 | 411,892,248.30 | 336,431,449.44 | 00.00 | 1,599,898,666.11 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -886,617.58 | 00.00 | 00.00 | -886,617.58 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайланг үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -65,350,156.20 | 00.00 | -65,350,156.20 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 851,574,968.37 | 411,005,630.72 | 271,081,293.24 | 00.00 | 1,533,661,892.33 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | / төгрөгөөр / Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|----------------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 23,200,962.00 | 32,081,634.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 23,200,962.00 | 32,081,634.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 23,200,962.00 | 32,081,634.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,309,362.00 | 869,634.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,309,362.00 | 869,634.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,891,600.00 | 31,212,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,891,600.00 | 31,108,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 104,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 0.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 23,200,962.00 | 32,081,634.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 23,200,962.00 | 32,081,634.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 2,208,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,467,362.00 | 29,873,634.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,733,600.00 | - |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)-(I)-(I) | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 311,719,000.00 | 292,321,866.00 | 372,763,000.00 | 301,733,961.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 311,719,000.00 | 292,321,866.00 | 372,763,000.00 | 301,733,961.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 310,719,000.00 | 291,321,866.00 | 371,803,000.00 | 300,773,961.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 174,131,800.00 | 162,893,102.00 | 209,351,200.00 | 185,897,031.49 |
| 210101 | Үндсэн цалин | 127,584,800.00 | 120,847,037.00 | 156,493,200.00 | 133,747,487.29 |
| 210102 | Нэмэгдэл | 25,874,100.00 | 21,373,165.00 | 26,603,400.00 | 26,120,807.13 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 20,672,900.00 | 20,672,900.00 | 26,254,600.00 | 26,028,737.07 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,288,800.00 | 20,838,011.00 | 28,262,500.00 | 24,107,387.30 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,801,200.00 | 20,838,011.00 | 19,888,400.00 | 16,676,569.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,176,000.00 | 00.00 | 2,093,500.00 | 1,857,762.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,480,800.00 | 00.00 | 1,674,700.00 | 1,486,210.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 348,200.00 | 00.00 | 418,800.00 | 371,318.47 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,482,600.00 | 00.00 | 4,187,100.00 | 3,715,526.24 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,266,700.00 | 28,471,117.00 | 28,565,900.00 | 28,565,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,571,900.00 | 3,921,343.00 | 4,571,900.00 | 4,716,926.00 |
| 210302 | Тулш, халаалт | 24,574,800.00 | 24,549,774.00 | 23,874,000.00 | 23,848,974.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 120,000.00 | 00.00 | 120,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,342,600.00 | 18,311,080.00 | 22,507,000.00 | 20,798,755.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,007,400.00 | 2,244,080.00 | 1,857,400.00 | 2,266,466.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,049,200.00 | 14,049,200.00 | 17,343,600.00 | 15,340,940.00 |
| 210403 | Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр | 1,286,000.00 | 1,172,000.00 | 1,506,000.00 | 1,311,254.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 845,800.00 | 600,000.00 | 680,095.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 120,000.00 | 119,900.00 | 200,000.00 | 199,083.33 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 120,000.00 | 119,900.00 | 200,000.00 | 199,083.33 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 | 6,400,000.00 | 6,400,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | 6,400,000.00 | 6,400,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,172,500.00 | 8,015,000.00 | 5,685,700.00 | 1,929,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,172,500.00 | 8,015,000.00 | 5,685,700.00 | 1,929,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,960,400.00 | 2,959,720.00 | 1,367,200.00 | 1,367,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 320,000.00 | 604,800.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 288,400.00 | 287,720.00 | 288,400.00 | 288,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 301,000.00 | 301,000.00 | 320,000.00 | 320,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 121,000.00 | 121,000.00 | 154,000.00 | 154,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,436,200.00 | 48,713,936.00 | 69,463,500.00 | 31,509,104.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,436,200.00 | 48,713,936.00 | 69,463,500.00 | 31,509,104.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,000,000.00 | 1,000,000.00 | 960,000.00 | 960,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,000,000.00 | 1,000,000.00 | 960,000.00 | 960,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | 960,000.00 | 960,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 311,719,000.00 | 292,934,900.00 | 372,763,000.00 | 301,733,961.12 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 300,854,800.00 | 282,070,700.00 | 343,299,500.00 | 301,733,961.12 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 300,854,800.00 | 282,070,700.00 | 343,299,500.00 | 301,733,961.12 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 10,864,200.00 | 10,864,200.00 | 29,463,500.00 | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 10,864,200.00 | 10,864,200.00 | 29,463,500.00 | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 01 | 01 | 01 | 01 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01 | 01 | 01 | 01 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 23 | 20 | 23 | 21 |
| 620001 | Удирдах ажилтан | 06 | 03 | 06 | 06 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | 11 | 08 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 07 | 07 | 03 | 03 |
| 620004 | Гэрээт ажилтан | 00 | 00 | 04 | 04 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бүх шатны Хурлын шийдвэр, Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд 19 чиглэлээр 155 ажлыг гүйцэтгэж 87.3 хувийн биелэлттэй, В үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны А/04 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний

бүрэлдэхүүнтэй байгуулсан. Хяналтын баг жилийн ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж, удирдлагад тайлагнасан байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус байгууллагад 2021 оны 01 дүгээр сард тусгай сангуудын үйл ажиллагаанд, 2021 оны 10 дугаар сард 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж 11 зөвлөмж, 3 акт тогтоосон байна.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1.5 хувиар буюу 5,547.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,160.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлаас 1.5 хувиар буюу 7,060.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 5,295.2 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон

материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,134.3 мянган төгрөгөөр өссөн байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “Acolous” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 343,299.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 25,308.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 31,552.7 мянган төгрөг, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас хандив 2,208.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,966.1 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 405,334.7 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 343,299.5 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 31,552.7 мянган төгрөг, иргэд аж ахуйн нэгж байгууллагаас хандив 2,208.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,966.1 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 380,026.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 15,544.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,966.1 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас ковидын хэрэгсэл, ариутгалын бодис авахад 5,000.0 мянган төгрөг, шүлхийний пост ажиллуулах зардалд 10,000.0 мянган төгрөг, Миндуотайди ХХК-аас нохой устгалын зардалд 1,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/72 захирамжаар ковидын хяналт шалгалтад 1,000.0 мянган төгрөг, А/128 захирамжаар биотехникийн зардалд 500.0 мянган төгрөг, А/353 захирамжаар Хангайн орчимд самбар сүүдрэвч байршуулахад 2,500.0 мянган төгрөг, иргэдээс ковидын хандивт 1,208.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 869.6 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал ковидын хандивт 500.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас сумын хамтарсан багт 400.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс статистик хариуцсан ажилтанд 104.0 мянган төгрөг, Зуунмод сумын нэмэлт санхүүжилтээс сургалтын шатахууны зардалд 134.3 мянган төгрөг, нийт 36,726.9 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна.

Зардал:

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт зардлыг 470,684.9 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 372,526.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өвс худалдан авахад 14,500.0 мянган төгрөг, ковидын эргүүл хяналт шалгалт хийхэд 1,000.0 мянган төгрөг, нохой устгалын зардалд 1,000.0 мянган төгрөг, био техникийн арга хэмжээнд 500.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогод 869.6 мянган төгрөг, ЭМТ-ийн халдвар хамгааллын хувцас хэрэгсэлд 1,208.0 мянган төгрөг, Хангайн баруун талд самбар, сүүдрэвч байршуулахад 2,500.0 мянган төгрөг, ковидын хэрэгсэл, ариутгалын бодис авахад 5,000.0 мянган төгрөг, шүлхийний пост ажиллуулахад 5,000.0 мянган төгрөг, хамтарсан багийн үйл ажиллагаанд 400.0 мянган төгрөг, статистик хариуцсан ажилтанд 104.0 мянган төгрөг нийт 32,081.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 4,645.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140455001 тоот дансанд 343,299.5 мянган төгрөгийн орлого, 343,299.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140455408 тоот дансанд 36,726.9 мянган төгрөгийн орлого, 36,726.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,051,224.6 мянган төгрөг, тайлант онд үнэ төлбөргүй хүлээж авсан 23,281.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө, урсгал төсвөөс 7,500.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2,270.7 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 16,239.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,476.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,167.5 мянган төгрөгийн программ хангамж, нийт 21,153.6 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор шийдвэрлэн акталж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,060,872.3 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 91,497.4 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 39,564.3 мянган төгрөг, ОБГ болон иргэд аж ахуйн нэгж байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан аж ахуйн материал, бусад хангамжийн материал 2,027.0 мянган төгрөг, нийт 41,591.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 37,364.4 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, мал амьтадын дансанд бүртгэлтэй 9,573.3 мянган төгрөгийн 4 адуу, 4 ухна, 7 хуцыг байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт, ажлын хэсгийн тодорхойлолт /нягтлан бодогч, нярав, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, мал эмнэлгийн мэргэжилтэн, багийн засаг дарга/, малчны тэмдэглэл, зураг зэргийг үндэслэн данснаас хасаж, бараа материалын эцсийн үлдэгдэл 86,151.0 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна. Авлагын дансаар гүйлгээ гараагүй байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 98,773.9 мянган төгрөг, нэмэгдсэн 378,971.2 мянган төгрөг, хасагдсан 378,971.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 98,773.9 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 8 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 86,151.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,447,609.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | /мянган төгрөг/ | | |
|--|-------------------|--------------------|-----------|
| | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 91,497.4 | 86,151.0 | -5,346.4 |
| Үндсэн хөрөнгө | 1,507,613.4 | 1,447,609.6 | -60,003.8 |
| Нийт хөрөнгө | 1,599,110.8 | 1,533,760.6 | -65,350.2 |
| Өр төлбөр | 98.8 | 98.8 | 0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,599,012.0 | 1,533,661.8 | -65,350.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,599,110.8 | 1,533,760.6 | -65,350.2 |

Авлагын данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна. Авлагын дансаар дамжсан гүйлгээ гараагүй байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 98,773.9 мянган төгрөг, нэмэгдсэн 378,971.2 мянган төгрөг, хасагдсан 378,971.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 98,773.9 төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 86,151.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 5,346.4 мянган төгрөгөөр буурсан нь мал амьтадын дансанд бүртгэлтэй 9,573.3 мянган төгрөгийн 4 адуу, 4 ухна, 7 хуцыг байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт, ажлын хэсгийн тодорхойлолт, малчны тэмдэглэл, зураг зэргийг үндэслэн данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,447,609.6 мянган төгрөг болж 60,003.8 мянган төгрөгөөр буурахад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 2,270.7 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 16,239.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 1,476.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,167.5 мянган төгрөгийн программ

хангамж, нийт 21,153.6 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор шийдвэрлэн акталж устгасан нь голлох нөлөөллийг үзүүлсэн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 90,785.1 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 21,153.6 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 1,533,760.6 мянган төгрөг болж, 65,350.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 352,672.2 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, нийт урсгал зардалд 352,672.2 мянган төгрөг төлөвлөж, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний зардал төлөвлөөгүйгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 9,372.7 мянган төгрөгөөр бууруулан сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 06 тоот тогтоолоор 2021 оны төсвийн орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал зардлын эх үүсвэрийг 343,299.5 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 343,299.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн явцад тодотгол хийгээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс урсгал санхүүжилтийг бүрэн авч, 301,733.9 мянган төгрөгийн буюу 87.9 хувийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 41,565.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын баяр наадмын зардлаас сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/160 дугаар захирамжаар ЭМТ-д хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат авахад 1,500.0 мянган төгрөг, ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулан шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг, ЗДТГ-т сумын онцгой комиссын үйл ажиллагаа гал командын зориулалттай 15 нэр төрлийн аж ахуйн материал 2,500.0 мянган төгрөгөөр шийдвэрлэж зарцуулсан байна.

Засаг даргын 2021 оны 12 дүгээр сарын 21-ний өдрийн А/167 дугаар захирамжаар ховор ан амьтад тархсан агнуурын бүс нутгуудад биотехникийн арга хэмжээ авч 100 боодол өвс, 8 тонн хужир, 2,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

ЗДТГ нь сумын Засаг даргын 02 тоот удирдамжийн дагуу ангийн нөхөрлөлүүдтэй хамтран Бригадын уул, Бага Хайрхан, Баянгийн уул, Хойд өнжүүл ууланд биотехникийн арга хэмжээний ажлыг 3 удаа зохион байгуулж ан агнах,

байгалийн ургамал түүж бэлтгэх цаг үеийн шинжтэй болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар хууль бус ангийн 1 зөрчлийг илрүүлэн 764.0 мянган төгрөгийн торгууль нөхөн төлбөр тавьж барагдуулан мэдээллийг Тамгын газрын цахим хаягаар нийтэд мэдээлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Бараа материалын дансанд 2021 оны ээхнд 2,968.0 мянган төгрөгийн үнэтэй 424 боодол өвсний үлдэгдэлтэй байсан. Тайлант онд нэг бүр нь 14.5 мянган төгрөгийн үнэтэй 1000 боодол всийг 14,500.0 мянган төгрөгөөр худалдан авч, 14.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 42 боодол өвсийг 609.0 мянган төгрөгөөр борлуулж, нэг бүр нь 7.0 мянган төгрөгийн үнэтэй 341 боодол өвс үнэ төлбөргүй зарцуулж, тайлант оны эцэст 14472.0 мянган төгрөгийн өвсний нөөцийн үлдэгдэлтэй байна. ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 11 хуцыг тэжээхэд 2021 оны 02 дугаар сарн 01ээс 6 дугаар сарын 15-ныг хүртэл хугацаанд 341 боодол өвсийг үнэ төлбөргүй зарцуулсан байна.

ЗДТГ нь мал амьтадын дансанд бүртгэлтэй 9,573.3 мянган төгрөгийн 4 адуу, 4 ухна, 7 хуцыг байгууллагын өмч хамгаалах комиссын дүгнэлт, ажлын хэсгийн тодорхойлолт, малчны тэмдэглэл, зураг зэргийг үндэслэн данснаас хасаж, бараа материал актласны зардалд бичсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 136 мэдээлэл байршуулж, 13 мэдээлэл хугацаа хоцроож 95.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”,

4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 6 дугаар сарын 15-ны 02/197 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй төрийн албан хаагчийн орон сууцны ашиглалт, хамгаалалтыг тодорхой, ил тод болгож, орон сууцыг түрээслүүлж, ашиглуулсны төлбөр болон, өмнөх жилүүдэд хувьчлагдсан 5 хаусыг борлуулсны орлогыг төсөвт төвлөрүүлсэн эсэх
- Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулж байх асуудлуудыг Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 109,787.4 мянган төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, 46,210.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 36,689.9 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,712.9 мянган төгрөгийн 3 зөрчилд акт тогтоож, 25,173.8 мянган төгрөгийн материаллаг бус 4 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэлийг татан төвлөрүүлсэн 46,210.8 мянган төгрөгөөр тохируулаагүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” - ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр сумын Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 18-ны А/135, 2021 оны 12 дугаар сарын 21-ний А/168 дугаар

захирамжуудаар 951.7 мянган төгрөгийг хүлээн авалт, шинэ жилийн арга хэмжээнд зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Мэргэжлийн хяналтын газарт актын төлбөрт 2021 оны 12 дугаар сарын 27-нд гэрэл цахилгааны зардлаас 99.6 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 10.6 мянган төгрөг, нийт 110.2 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

Татварын албаны тодорхойлолтоор цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварын 651.0 мянган төгрөгийн илүү төлөлттэй, санхүүгийн болон татварын тайлан мэдээнд тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн

баталж, хэрэгжүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Эрх ба үүрэг”, “Тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Худалдан авалт хийсэн 7 байгууллага, иргэдээс 29,189.9 төгрөгийн санхүүгийн гүйлгээг е баримт, е посоор баримтжуулж баталгаажуулаагүй зөрчил байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “ хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр урсгал төсвөөс 7,500.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шатах тослох материалын зарлагын гүйлгээнд 365.0 мянган төгрөгийн шатахууныг бичиг хэрэг, цэвэр бохир ус, шуудан холбооны зардалд гүйлгэн зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “Толилуулга”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Шатах тослох материалын орлого, зарлагын гүйлгээг шалгахад 7,372.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын дансны бичилт буруу, тооцоолол дутуу зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Дансны бичилтийг зөв бичих, Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулж байх

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Татварын албаны тодорхойлолтоор “Суутган-2” тайланд 17,436.7 мянган төгрөгийн илүү төлөлтийн суутгагчийн орлогыг тайлагнаагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, “Эрх ба үүрэг”, “Тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Татварын “Суутган -2” тайланд суутгагчийн орлогыг үнэн зөв, бүрэн тайлагнах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|-----|---|-------------------|-----------|-----------|----------|---------------|---------|-----------------|----------|---------|----------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Баян-Өнжүүл сумын Засаг даргын Тамгын газар | 10 | 109,787.4 | 1 | 46,210.8 | 3 | 1,712.9 | 2 | 36,689.9 | 4 | 25,173.8 |